



БАТЛАВ  
“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨЛК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
М.МОНХӨӨ

БАТЛАВ  
АЛТАН ГАРДЕН ХӨГЖИЛ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ  
Г.МАРТ



### АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2023 оны 11 сарын 06 өдөр

Дугаар 2023/98

Улаанбаатар хот

Нэг талаас “Амгалан дулааны станц” Төрийн өмчит хувьцаат компани /цаашид “Захиалагч” гэх-/ийг төлөөлж Гүйцэтгэх захирал М.Монхөө негөө талаас Алтан гарден хөгжил ХХК-ийг төлөөлж захирал Г.Март /цаашид “Гүйцэтгэгч” гэх/ нар Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дүгээр зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус тус үндэслэн дараах зүйлүүдийг харилцан тохиролцож энэхүү гэрээг (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

#### Нэг. Гэрээний зорилго

1.1 Гэрээний зорилго нь “Дотоод хэрэгцээний ялтсан бойлер угаалгах” ажлыг дор дурдсан хугацаанд гүйцэтгэж захиалагч талд хэвийн үйл ажиллагааг ханган хүлээлгэж өгөх, Захиалагч нь гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлийг дүгнэж зохих шаардлагыг хангасан гэж үзвэл энэхүү гэрээгээр тохирсон хугацаанд ажлын хөлсийг төлөх, харилцан үүрэг хүлээх, ажил эхлэх, гүйцэтгэх, дуусах явцтай холбоотой үүссэн харилцааг зохицуулахад оршино.

#### Хоёр. Гэрээний нөхцөл , ерөнхий зүйл

2.1 Гүйцэтгэгч нь “Дотоод хэрэгцээний ялтсан бойлер угаалгах” (цаашид “ажил” гэх) -ыг энэхүү гэрээний салшгүй хэсэг болох хавсралтад заагдсан хугацаанд багтаан хийж гүйцэтгэнэ. Компанийн горим ажиллагаатай холбоотойгоор эхлэх өдрийг мөрдөх боломжгүй болсон бол наряд нээгдсэн өдрөөр тооцож болно.

2.2 Ажил гүйцэтгэх хугацаа гэрээ байгуулагдсан өдрөөс 30 хоногт багтаана.

2.3 Ажлын баталгаат хугацаа гэрээт ажлыг хүлээлгэн өгснөөс хойш 1 жил байна.

#### Гурав. Үнэ төлбөрийн нөхцөл

3.1 Энэхүү гэрээний нийт үнэ 3,795,000 /гурван сая долоон зуун ерэн таван мянга/-н төгрөг бөгөөд үнийн дүнд НӨАТ багтсан байна.

3.2 Захиалагчаас гүйцэтгэгчид урьдчилгаа төлбөр төлөхгүй.

3.3 Ажил хүлээлгэн өгсний дараа хүлээн авсан акт, гэрээ дүгнэсэн актыг үндэслэн 15 хоногийн дотор төлбөрийг нэхэмжлэлийн дагуу гүйцэтгэгчийн Голомт банкны 3105136490 тоот дансанд шилжүүлнэ.

Захиалагч:

1/4

Гүйцэтгэгч:

## **Дөрөв. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг**

- 4.1 Гэрээт ажлыг ажил гүйцэтгэх гэрээнд заагдсан үнэд багтаан батлагдсан хугацаанд чанартай хийж гүйцэтгэнэ.
- 4.2 Баталгаат хугацааны дотор гүйцэтгэгчийг ажлын чанараас шалтгаалан гэмтэл гарсан нь актаар батлагдвал үнэ төлбөргүй дахин хийж гүйцэтгэж хохирлыг барагдуулна.
- 4.3 Гэрээт ажлыг гүйцэтгэхдээ ажилтнуудыг хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйг бүрэн хангуулах, галын аюулаас урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээг авч ажиллах ба эдгээр шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагч байгууллагын шаардлагаар ажлыг зогсоон.
- 4.4 Ажил гүйцэтгэх хугацаанд Эрчим хүчний системд мөрдөж буй Техник Ашиглалтын Дүрэм, Аюулгүй Ажиллагааны Дүрэм болон холбогдох бусад дүрэм журмын мөрдөж ажиллана. Захиалагчийн тавьсан шаардлага зөвлөмжийг заавал биелүүлнэ.
- 4.5 Ажил гүйцэтгэхдээ шаардлагатай багаж тоног төхөөрөмжийг станцын хашаанд оруулах үед тоо хэмжээг харуулд бүртгүүлэн эрх бүхий албан тушаалтнуудын зөвшөөрөл, хяналтаар нэвтрүүлнэ.
- 4.6 Гүйцэтгэгч тал захиалагчийн зөвшөөрөлгүйгээр гэрээний эрх үүрэг, хариуцлагыг бусдад шилжүүлэхгүй байх үүрэгтэй
- 4.7 Ажлыг гүйцэтгэгч компани нь уг ажлыг гүйцэтгэх явцад нарядын системийг чанд мөрдөнө.

## **Тав: Захиалагчийн эрх, үүрэг**

- 5.1 Хөдөлмөрийн Аюулгүй Байдал, Аюулгүй Ажиллагааны Дүрмийн шаардлагыг биелүүлэхээс татгалзсан эсэргүүцсэн, дүрэм стандартыг зөрчсөн чанарын гологдол гаргасан тохиолдолд гэрээт цуцлах хүртэл арга хэмжээг авах эрхтэй.
- 5.2 Баталгаат хугацаанд Гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэсэн ажилтай холбоотой гэмтэл доголдол гарвал дахин үнэ төлбөргүй хийж гүйцэтгэхийг шаардах эрхтэй.
- 5.3 Гүйцэтгэсэн ажлыг хугацаанд нь ажлын комисс хүлээн авна.
- 5.4 Ажил гүйцэтгэх явцад гүйцэтгэгчийн ажилд захиалагч талаас хяналтыг тогтмол тавьж ажиллана.
- 5.5 Захиалагч талаас гэрээний үнийн дүнг өөрчлөхгүйгээр нэмэлт ажил, ажлын тоо хэмжээнд гүйцэтгэгчтэй тохиролцсоны үндсэн дээр өөрчлөлт оруулж болно.

## **Зургаа. Талуудын хүлээх хариуцлага**

- 6.1 Гүйцэтгэгч нь гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд нийт үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид хоног тутам төлөх ба нийт алдангийн үнийн дүн гэрээний нийт үнийн дүнгийн 10%-иас хэтрэхгүй байна.
- 6.2 Захиалагч нь ажлын гүйцэтгэл, техникийн үзүүлэлт, шаардлагад тохирч байгаа эсэхийг шалган үзээд хүлээн авсны дараа гэрээнд заасан хугацаанд тооцоо хийх, төлбөрийн хугацааг хожимдуулбал хожимдсон хоног тутамд хүлээгдэж байгаа

Захиалагч:

2/4

Гүйцэтгэгч:

төлбөрийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг нийлүүлэгчид төлөх ба алдангийн дүн нь гэрээний хүлээгдэж байгаа төлбөрийн үнийн дүнгийн 10%-иас хэтрэхгүй байна.

- 6.3 Захиалагчийг төлөөлж гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлыг Барилга, сантехник, дулаан хангамжийн инженер Б.Адарсүрэн хариуцан ажиллана. Утас-99810004.
- 6.4 Гүйцэтгэгчийг төлөөлж гэрээтэй холбоотой асуудлыг Алтан гарден хөгжил ХХК-ийн захирал Г.Март хариуцан ажиллана. Утас- 99078943
- 6.5 Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэсний дараа дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд:
- Тухайн тоноглолтой холбоотой баримтууд  
ажлын тайлан 3хувь
  - Гүйцэтгэсэн ажлуудыг фото зургаар  
баримтжуулан хавсаргах 3хувь

### **Долоо. Давагдашгүй хүчин зүйл**

- 7.1 Гэрээг хэрэгжүүлэх явцад улс төрийн хориг, байгалийн гамшиг, хорио цээр тогтоох, цэргийн үймээн, төрийн эргэлт, ажил хаялт болон бусад нөхцөлүүд бий болсноос үүдэж гэрээний нөхцөлүүд хэсэгчлэн болон бүрэн биелээгүй тохиолдолд хоёр талын аль нь ч хариуцлага хүлээхгүй.
- 7.2 Давагдашгүй хүчин зүйлийн нөхцөлүүд гарч эхэлсэн тохиолдолд гэрээний хугацаа дуусахаас 10 хоногийн өмнө талууд бие биедээ бичгээр мэдээлж цаашид хэрхэн ажиллах талаар зөвшилцөнө.
- 7.3 Давагдашгүй хүчин зүйл гэдгийг зөвхөн Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхим батална.

### **Найм. Гэрээг цуцлах үндэслэл**

- 8.1 Гүйцэтгэгч нь ажлыг энэхүү гэрээний 2.1-т заасан хугацаанаас хэтрүүлсэн тохиолдолд Захиалагч гэрээг цуцлах тухай мэдэгдлийг Гүйцэтгэгчид албан ёсоор бичгээр өгнө. Гүйцэтгэгч уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор зохих хариуг өгч тодорхой арга хэмжээ авахгүй тохиолдолд Захиалагч гэрээг цуцална.
- 8.2 Гүйцэтгэгч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд Захиалагч энэхүү гэрээний үйлчлэлийг дуусахаас өмнө тасалдуулахгүй.

### **Ес. Бусад нөхцөл**

- 9.1 Талуудын аль нэг нь нөгөөдөө гэрээтэй холбогдох мэдээлэл солилцох тохиолдолд мэдээллийг авсан тал хуанлийн 7 хоногт багтаан нөгөө талдаа тавьсан асуудлаар тодорхой хариу өгнө.
- 9.2 Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гурав дахь талд шилжүүлэхийг хориглоно.
- 9.3 Гэрээг монгол хэл дээр 3 хувь үйлдэж, Захиалагч 2 хувийг Гүйцэтгэгч 1 хувийг авах бөгөөд хувиуд ижил тэгш хүчинтэй.
- 9.4 Гэрээг хоёр тал зөвшөөрсөн тохиолдолд 1 удаа сунгаж болно.
- 9.5 Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр байна.

Захиалагч: 

3/4

Гүйцэтгэгч:

- 9.6 Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмж засварласан эх хувьд баллаж засварласан буюу гараар нэмж бичсэн болон бусад энгийн аргаар хийсэн оруулга засвар нэмэлт бичилтийг хүчинтэйд тооцохгүй.
- 9.7 Энэхүү гэрээнд шууд заагаагүй бусад аливаа асуудлыг Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

### ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН  
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

 Э.МОНХЖАРГАЛ

АЖ АХУЙ, ХАНГАМЖИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

 Г.БАТТУЛГА

СЭЗХ-ИЙН ДАРГА  
БӨГӨӨД ЕРӨНХИЙ  
НЯГТЛАН БОДОГЧ

 О.УДВАЛ

ИНЖЕНЕРИЙН ХЭСГИЙН  
АХЛАХ ИНЖЕНЕР


 Т.АНГАРАГ

ХУУЛИЙН  
МЭРГЭЖИЛТЭН

 Г.САРУУЛ

ГЭРЭЭ БОЛОВСРУУЛСАН :

ЦХАХАЖилтан  
Б.ДУЛАМСҮРЭН




Хаяг: Монгол улс, Улаанбаатар  
хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, УС-15-1-1  
Утасны дугаар: 77111251  
РД: 6021646

### ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

АЛТАН ГАРДЕН ХӨГЖИЛ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

 Г.МАРТ

Захиалагч:



4/4

Гүйцэтгэгч:

